

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**



**ТЭЭВРИЙН САЛБАРЫН
ТАНИЛЦУУЛГА 2015**



**УЛААНБААТАР ХОТ
2016 ОН**




Чингэлтэй дүүргийн автомашины тоо

2015 оны байдлаар Чингэлтэй дүүрэгт бүртгэлтэй автомашины тоо 36.7мянга байгаа нь 2012 оны мөн үеэс 45.8 хувь, 2013 оны мөн үеэс 28.9 хувь, өнгөрсөн оны мөн үеэс 13.0 хувиар тус тус өссөн байна. Нийслэл хотод бүртгэлтэй автомашины 11.1 хувийг Чингэлтэй дүүрэг эзэлжээ.

Хүснэгт 1. Техникийн хяналтын улсын үзлэгт хамрагдсан автомашины тоо, 2015 он /хороодоор/

Хороо	Нийт автомашины тоо	Амины автомашины тоо		
		2013 он	2014 он	2015 он
1	1879	758	788	856
2	1843	689	796	899
3	3509	1565	2514	2775
4	2177	1041	1155	1376
5	1612	1036	1136	1264
6	2175	1474	1735	1803
7	2441	1631	1824	2097
8	1078	749	728	850
9	1539	1178	1168	1230
10	1643	968	1225	1437
11	1073	862	882	907
12	2261	1310	1594	2003
13	1847	1133	1395	1621
14	1747	1691	1549	1552
15	1798	1077	1142	1595
16	2148	1251	1532	1931
17	2062	1314	1546	1878
18	1994	1382	1533	1814
19	1877	1287	1440	1793
Дүүргийн дүн	36703	22396	25682	29681
Нийслэлийн дүн	331564	203573	238183	265352



Зураг 1. Техникийн хяналтын улсын үзлэгт хамрагдсан автомашины тоо, 2015 он /дүүргээр/

Нийслэл хотод техникийн үзлэгийн дүнгээр 331.6 мянган тээврийн хэрэгсэл хамрагдсан байна. Техникийн хяналтын улсын үзлэгийн дүнд Улаанбаатар хотын хамгийн өндөр хувийг Баянзүрх дүүрэг 26.3 хувь буюу 87.2 мянган тээврийн хэрэгсэл, үүнээс амины автомашин 69.7 мянга, хамгийн бага хувийг Багахангай дүүрэг 0.1 хувь буюу 0.4 мянган тээврийн хэрэгсэл, үүнээс 0.3 амины автомашин байна. Чингэлтэй дүүргийн хувьд

нийслэлийн дүнд 11.1 хувийг эзэлсэн бөгөөд үүнээс 29.7 мянга нь амины автомашин байна.

Зураг 2. Дүүргийн нийт автомашины тоо, 2015 он /хороодоор /



Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2015 оны техникийн хяналтын улсын үзлэгт 36.7 мянган автомашин хамрагдсан байна. Хороодын дүнд эзлэх хамгийн өндөр буюу 9.6 хувийг дүүргийн 3-р хороо эзэлжээ.

Хүснэгт 2. Автомашины тоо, өмчийн хэлбэрээр 2014-2015 он

	Бүгд	Үүнээс: Автомашины үндсэн төрлөөр				
		Суудлын	Ачааны	Автобус	Тусгай	
2014 он						
Дүүргийн дүн	32481	24460	5819	1190	1012	
Аж ахуйн нэгжийн автомашин	Төрийн болон орон нутгийн өмчийн	852	667	51	100	34
	Дипломат, олон улсын байгууллагын	61	50	3	8	
	Төрийн бус байгууллагын	298	154	66	21	57
	Компани, хоршоо, нөхөрлөлийн	5588	3400	1206	263	719
Амины автомашин	25682	20189	4493	798	202	
2015 он						
	Бүгд	Суудлын	Ачааны	Автобус	Тусгай	
Дүүргийн дүн	36703	28372	6560	1291	480	
Аж ахуйн нэгжийн автомашин	Төрийн болон орон нутгийн өмчийн	903	697	69	112	25
	Дипломат, олон улсын байгууллагын	66	56	3	7	
	Төрийн бус байгууллагын	227	124	74	15	14
	Компани, хоршоо, нөхөрлөлийн	5826	3717	1504	290	315
Амины автомашин	29681	23778	4910	867	126	

Техникийн хяналтын үзлэгийн 2015 оны дүнгээр нийт тээврийн хэрэгслийн 19.1 хувь нь аж ахуй нэгж байгууллагын эзэмшилд бүртгэлтэй байгаагийн 2.5 хувийг төрийн болон орон нутгийн өмчийн, 0.2 хувийг дипломат, олон улсын байгууллагын, 0.6 хувийг төрийн бус байгууллагын, 15.9 хувийг компани, хоршоо, нөхөрлөлийн автомашин тус тус эзэлж байна. Хувь хүмүүс, иргэдийн эзэмшилд бүртгэлтэй амины автомашины тоо 29.7 мянгад хүрсэн нь нийт автомашины 80.9 хувь байна.

Зураг 3. Автомашины тоо үндсэн төрлөөр, 2015 он



Дүүргийн нийт автомашины 64.8 хувийг суудлын автомашин, өмнөх оны мөн үеэс 17.8 хувиар, автобус өмнөх оны мөн үеэс 8.2 хувиартус тус өссөн, тусгай зориулалтын автомашин 56,3 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 3. Автомашины тоо, хөдөлгүүрийн төрлөөр 2015 он

	Бүгд	Үүнээс: Автомашины үндсэн төрлөөр			
		Суудлын	Ачааны	Автобус	Тусгай
Бензин хөдөлгүүр	19179	18381	540	231	27
Дизель хөдөлгүүр	9499	2068	5941	1041	449
Цахилгаан	6700	6687	13	-	-
Газ	1325	1236	66	19	4
Нийт	36703	28372	6560	1291	480

Техникийн хяналтын улсын үзлэгт хамрагдсан дүүргийн 36,7 мянган автомашиныг хөдөлгүүрийнх нь шатахууны төрлөөр ангилж үзэхэд 52,2 хувь нь “Бензин хөдөлгүүртэй”, 25,9 хувь нь “Дизель хөдөлгүүр”-тэй, үлдсэн 21,9 хувь нь “Цахилгаан болон Газ” хөдөлгүүртэй автомашин.

Зураг 4. Дүүргийн нийт машины тоо, 2015 он /хороодоор/


Чингэлтэй дүүргийн “Тээврийн” салбарын танилцуулга-2015



Хүснэгт 4. Автомашинны тоо, ашиглалтын хугацаа, 2015 он /дүүргээр/

	2014 он				2015 он			
	Бүгд	0-3 жил	4-9 жил	10-с дээш	Бүгд	0-3 жил	4-9 жил	10-с дээш
Суудлын	24160	1044	5668	17448	28372	828	6746	20798
Ачааны	5819	231	740	4848	6560	137	994	5429
Автобус	1190	60	191	939	1291	73	201	1017
Тусгай	1012	270	477	265	480	105	195	180
Дүүргийн дүн	32481	1605	7376	23500	36703	1143	8136	27424

Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2015 оны техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт автомашины 74,7 хувийг арав ба түүнээс дээш жилээр ашигласан тээврийн хэрэгсэл эзэлсэн энэ нь өмнөх оны мөн үеэс 16.7 хувиар өссөн байна. 22.2 хувийг 4-9 жил ашигласан тээврийн хэрэгсэл, үлдсэн 3.1 хувийг 0-3 жил ашигласан тээврийн хэрэгсэл тус тус эзэлжээ.



Зураг 5.
Автомашинны тоо, хүрдний байрлалаар, 2015 он

Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт автомашины 59.6хувийг нь жолооны хүрд баруун талдаа буюу “буруу талдаа” байрлалтай байна. Автомашины төрлөөр нь авч үзвэл 94.7 хувийг суудлын автомашин эзэлжээ. Суудлын автомашины 73.0 хувь нь баруун талдаа, 27.0 хувь нь зүүн талдаа хүрдний байрлалтай байна. Зүүн талдаа буюу зөв талдаа хүрдний байрлалтай автомашины 51.6 хувь нь суудлын автомашин эзэлсэн ба нийт ачааны машины 84.8хувь нь, автобусны 90.4 хувь нь, тусгай зориулалтын 91.9 хувь нь зөв талдаа хүрдтэй автомашин байна. Манай улсад замын хөдөлгөөний дүрэмдээ баруун гарын дүрэм баримталдаг тул зөв талдаа буюу жолооны хүрд нь зүүн талдаа байрлалтай тээврийн хэрэгсэл ашиглах нь эерэг үзүүлэлт юм.

Хүсэгт 5. Автобусны буудлын тоо, төвийн дүүргүүдээр

Дүүрэг	2014 он			2015 он			Зогсоолын талбайн стандартын шаардлага хангасан	Зогсоолын тэмдэгтэй
	Бүгд	Үүнээс:		Бүгд	Үүнээс:			
		Эцсийн	Дундын		Эцсийн	Дундын		
Хан-Уул	59	9	50	59	9	50	25	17
Баянзүрх	190	19	171	190	19	171	132	94
Баянгол	76	3	48	76	3	73	47	58
Сүхбаатар	119	5	15	130	7	123	61	79
Чингэлтэй	72	7	18	103	6	97	75	66
Сонгинохайрхан	195	25	62	195	25	170	56	101
Нийт	711	68	643	753	69	684	396	415


Нийслэлд ажиллаж буй автобусны буудал, зогсоолын хамгийн олонх нь буюу 25.2-25.9 хувь нь нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт байршдаг ба автобусны арван буудал тутмын нэг нь Чингэлтэй, Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт тус тус байрлаж байхад Хан-Уул дүүрэгт хамгийн цөөн буюу 59 буудал, зогсоол байрладаг байна.

Хүснэгт 6. Тээврийн үндсэн үзүүлэлт

Он	Тээсэн ачаа (мян.тн)		Улсын дүнд УБ хотын эзлэх хувь	Тээвэрлэсэн зорчигч (сая.хүн)		Улсын дүнд УБ хотын эзлэх хувь
	Монгол Улсад	Нийслэл хотод		Монгол Улсад	Нийслэл хотод	
2015	16682.2	1628.7	9.8	256.5	238.3	92.9
2014	23514.2	2914.0	12.4	340.1	284.9	83.8
2013	21321.9	2582.2	12.1	303.4	262.8	86.6
2012	30195.1	3211.4	10.6	313.2	236	75.4
2011	25635.3	3086.6	12.0	291.8	234.7	80.4

2015 онд авто тээврээр улсын хэмжээнд тээвэрлэсэн нийт зорчигчдын 92.9 хувь, тээсэн нийт ачааны 9.8 хувь нь нийслэл хотод тус тус ногдож байна. Тээсэн ачааны улсын дүнд нийслэл хотын эзлэх хувь өмнөх оныхоос 2.6 пунктээр буурав. Харин авто тээврээр тээвэрлэсэн зорчигчийн улсын дүнд нийслэл хотын эзлэх хувийн жин өмнөх оныхоос 9.1 пунктээр өссөн нь сүүлийн таван жилд гарч буй хамгийн өндөр үзүүлэлт юм.

Зураг 6. Хүлээлтийн хугацаа, минут



2015 онд нийтийн тээврийн үйлчилгээний сүлжээг шинэчилсэн төлөвлөлтийн дагуу явуулах ажлын хүрээнд зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлүүдийн давхцалыг арилгах арга хэмжээ авагдаж, төрийн автобусны үндсэн чиглэлээс гадна дунд багтаамж, туслах болон зуслангийн чиглэлийн тоо багасч, эдгээр чиглэлүүдэд ажиллах тээврийн хэрэгслийн тоо өмнөх оныхоос 6.0-35.0 хувиар буурсан байна. Үүнтэй уялдан зогсоолд ирэх автобус хоорондын зай буюу нийтийн тээврийн хүлээлтийн дундаж хугацаанд зохих өөрчлөлтүүд гарч, өмнөх оныхтой харьцуулахад бага багтаамжийн автобусны хүлээлт 3.8 минутаар, цахилгаан тээврийнх 0.8 минутаар нэмэгдэж, их багтаамжийн автобусны хүлээлтийн хугацаа 0.3 минутаар буурсан байна.